

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар

2022 оны жилийн эцэс

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх			
1	1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Төрийн албан хаагчдын чадавхжуулах сургалтын хүрээнд Удирдлагын академитай хамтран дунд, богино хугацааны сургалтад ТЖАХ-ыг үе шаттайгаар сурган бэлтгэж байна.Үүнд: - Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх богино хугацааны сургалт -Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх дунд хугацааны сургалт - Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт - Ахлах түшмэлийн сургалт - Эрхэлсэн түшмэлийн сургалт төрийн жинхэнэ албан хаагч хамрагдсан. Иргэдийн итгэл хүлээсэн, ёс зүйтэй төрийн албыг цогцлоон хөгжүүлэх нь төрийн албаны шинэтгэлийн үндсэн зорилгын хүрээнд Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр төрийн албан хаагчийн хандлага, соёл, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, төрийн албаны бүтээмж, үр нөлөөг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчин, онол практик, арга зүйн асуудлыг төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан Ховд аймагт “Төрийн албаны шинэтгэл - төрийн бүтээмж” сэдэвт 2 өдрийн сургалт-зөвлөгөөн сургалтыг УИХ-ын байнгын хороотой хамтран зохион байгуулж, 2022 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн сургалт-зөвлөгөөнд аймгийн 17 сум, төрийн байгууллагын 250 гаруй удирдах ажилтан тушаалтан, 02 дугаар сарын 28-ны өдрийн сургалт-зөвлөгөөнд 190 гаруй төрийн албан хаагчид оролцлоо. Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хэрэгжүүлэхийн тулд төрийн албан хаагчийг тасралтгүй сургаж, мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэн мэргэшүүлэх цахим сургалтын тогтолцоог төрийн албанд хэрэгжүүлэх бодлогын хүрээнд Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн 7:4:10 “Пүрэв гараг”-ийн 32 удаагийн цахим сургалтад аймаг, сумдын нутгийн захиргааны байгууллагууд нийт 149 төсөвт байгууллагуудын 41947 төрийн албан хаагчид хамрагдлаа.	100%
2	2. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад	2022 оны 7 дугаар сарын 21-ны өдөр Ховд аймаг Ба БНХАУ-ын Цонж Хуй өөртөө Засах аймагтай Байтаг-Улиастай боомтыг нээх тухай цахим хурал зохион байгууллаа. Манай аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболд, гадаад харилцааны мэргэжилтэн Б.Эрдэнэчимэг, сүлжээний инженер Б.Даваажаргал, Гаалийн ерөнхий газрын Ховд аймаг дахь салбарын дарг О.Лхагва-Эрдэнэ, хилийн цэргийн 0130 дугаар ангийн Түмэнжаргал нар оролцож Байтаг боомтын үйл ажиллагааг эхлүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, одоогийн нөхцөл байдлын талаар танилцуулав. “Алтай бидний нийтийн гэр” ОУЗЗ-ийн 16-р хуралдааны шийдвэрийн дагуу “ИХ Алтай буюу Great Altai” олон улсын аялал жуулчлал, спорын их наадмын 2023 онд Монголын талд зохион байгуулах шийдвэр гарсан. Энэхүү шийдвэрийн дагуу манай аймаг болон Баян-Өлгий аймаг хамтран	70%

	сургалт	зохион байгуулахаар төлөвлөөд байна.	
3	3. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Ариунбилэг нь Хүний эрхийн үндэсний комиссын тамгын газрын гомдол, хяналт шалгалтын хэлтсийн референтийн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэж нэр дэвшүүлэн томилогдохоор өөр ажилд шилжин ажиллахаар болсон тул Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Бямбасүрэнг шилжүүлэн томилсон. -Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн П.Цэцэгсүрэн нь Мал эмнэлэгийн газрын Захиргаа, санхүү албаны даргын албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэж, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалтын дагуу сэлгэн шилжүүлэн томилогдон ажиллаж байна.	90%
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах			
4	4. Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Тайлант онд албан хаагчдын цалин хөлсөнд 729,176,700 төгрөг, урамшуулалд 48,399,40 нэмэгдэлд 193,597,600 төгрөг, зарцуулж, энэ нь байгууллагын нийт төсвийн 62,2 хувийг эзэлж байна.	100%
5	5. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/169 дүгээр тушаалаар “Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын 2021-2024 онд хэрэгжүүлэх сургалтын болон нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”, 2022 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлын хэсгийг албан хаагчдаас сургалт, хөгжлийн үйл ажиллагаа, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах талаар санал асуулга авч нэгтгэн дүгнэхэд 93.0 хувьтай байна.	90%
6	6. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Тайлант 2022 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын 7 хэлтэс, 3 тасгийн 76 албан хаагчдыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд эрүүл мэндийн даатгалаар бүрэн шинжилгээнд хамруулан, нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт оруулж, Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг төлсөн байна. Түүнчлэн 2022 онд үйлчилгээний 12 албан хаагчдыг “Баянхонгор аймгийн Шаргалжуутын рашаан сувилалд ковидын дараах нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдуулж ажиллалаа.	100%
7	7. Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	Тайлант онд албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон ая тухтай орчин ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд нийт 41,903,200 төгрөг зарцуулав. - Цэргийн баяр, Олон улсын Эмэгтэйчүүдийн баярын хүндэтгэлийн арга хэмжээнд 8,053,700 төгрөг; - Шинэ жилийн баярын бэлэг өгөхөд-2,640,000 төгрөг; -64 ажилтанд дотоод журмын дагуу буцалтгүй тусламж үзүүлэхэд-9,300,000 төгрөг, - Эмнэлэгт хэвтсэн17, хуримын арга хэмжээ 6, буяны ажилд 4,158,000 төгрөг; тус тус зарцууллаа. - ажилчдын дархлааг дэмжиж короновирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор маск, гар ариутгагч, аарц, чацаргана өгөхөд 140000 мянга төгрөг; - Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилчдад тэтгэмж 17,611,500 төгрөг зарцуулав.	100%